

ДОРНОД АЙМАГ  
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/51

Чойбалсан

Г Үндсэн хөрөнгө орлогод авах тухай Г

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалт, Төрийн өмчийн хорооны "Төрийн өмчийн хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам", Эрүүл мэндийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төслийн хүрээнд ариутгалын тасагт нийлүүлэгдэж буй 775 348 151.71 төгрөг (долоон зуун далан таван сая гурван зуун дөчин найман мянга нэг зуун тавин нэгэн төгрөг далан нэгэн мөнгө)-ийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэхийг Нягтлан бодогч О.Солонгод үүрэг болгосугай.

2.Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, холбогдох баримтуудтай танилцан шалгаж, бүртгэн авч ариутгалын тасагт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Өмч хамгаалах комиссын дарга Ж.Энхчимэг, гишүүдэд даалгасугай.

3.Хүлээн авсан тоног төхөөрөмжийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд анхаарч ажиллахыг тасгийн эрхлэгч /Б.Ганганцэцэг/-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга Д.Ганхүрэлд хариуцуулсугай.

ЗАХИРАЛ  Д.ДОЛЖИН

УХА0033